



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2014 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: Монголбанкны Төв байрны 1 дүгээр давхрын вестибюлийг шинэчлэх засварын ажил хийж гүйцэтгэх

Тендер шалгаруулалтын дугаар: VL -2014/03

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос засварын ажил хийж гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендер нь 1 багцтай байна.

Тендерийн бичиг баримтыг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 100,000 (нэг зуун мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 120,000,000.00 төгрөг,

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 120,000,000.00 төгрөг,

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2012, 2013 он.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Тендерийг 2014 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2014 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

### МОНГОЛБАНК

*Бага тойруу -3, 15160, Улаанбаатар хот,*

*Монголбанкны "А" байрны 1 давхар 2 тоот өрөө,*

*Утас: (976) 11-310334, 329295, Факс: (976) 11-311471*